



“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО
IC-82 V-1.0

2022 он

Хамрах хүрээ: ИНВЕСКОР ББСБ ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	Хариуцах эзэн: Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо
Хувийг хадгалах: Хүний нөөцийн газар Хууль, эрсдэлийн удирдлагын газар	Танилцах: ИНВЕСКОР ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, нийт ажилтнууд
Хүчинтэй хугацаа: 2022 оны 06-р сарын 22-ны өдрөөс эхлэн	Хуудасны тоо. 3
Журмын Дугаар: IC-82	Хувилбар: V-1.0

Өөрчлөлтийн түүх

	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1.	V-1.0	2022.06.22	СЗХ-оос шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”- д нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулав.
2.			
3.			
4.			
5.			

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ **Error! Bookmark not defined.**
2. ЗАЛГАМЖ ХАЛААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ **Error! Bookmark not defined.**
3. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ . **Error! Bookmark not defined.**
4. БУСАД **Error! Bookmark not defined.**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “Инвескор ББСБ” ХК (“ББСБ”)-ын Залгамж халааны бодлого (“Бодлого”)-ын зорилго нь Компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг төлөвлөх, ББСБ-ын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангахад оршино.
- 1.2 Компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, эрх бүхий албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд залгамж халааг тодорхойлох хүрээнд энэхүү Бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3 Компанийн эрх бүхий албан тушаалтан гэдэгт дараах албан тушаалтнуудыг ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. ТУЗ-ийн дарга, гишүүд;
 - 1.3.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
 - 1.3.3. Гүйцэтгэх захирал;
 - 1.3.4. Дэд захирлууд;
 - 1.3.5. Газрын захирлууд;
 - 1.3.6. Зээлийн хорооны гишүүд.
- 1.4. ББСБ нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог байгуулах замаар Бодлогыг хэрэгжүүлнэ.

2. ЗАЛГАМЖ ХАЛААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- 2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь дотоод болон гадаад эх үүсвэрээс эрх бүхий албан тушаалтанд тохирох буюу шаардлага хангасан этгээдийг олж тодорхойлно.
- 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно.
- 2.3. Эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлж, үнэлж, дүгнэх замаар Бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.4. ББСБ-ын Хүний нөөцийн газар нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд судалгаа, тайлан хүргүүлэх, хамтарсан төлөвлөгөө гаргах замаар хамтарч ажиллана.
- 2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргана.
- 2.6. Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Нэр дэвшүүлэх хороо болон Хүний нөөцийн газар нь жил бүр судалгаа хийнэ.
- 2.7. ББСБ-ын бизнес төлөвлөгөөнд заасны дагуу үйл ажиллагааг өргөтгөх тохиолдолд шинээр гарч болзошгүй орон тоог Хүний нөөцийн газар нь Нэр дэвшүүлэх хороонд санал болгож, Нэр дэвшүүлэх хороо нь орон тоог ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, батлуулна.
- 2.8. Нэр дэвшүүлэх хороо нь ББСБ-ын алсын хараа, зорилго, зорилт, бизнес төлөвлөгөөний хүрээнд хийгдэх цаашдын өсөлт, хөгжилд шаардлагатай албан

- тушаалтнуудад тохиромжтой нэр дэвшигчид байгаа эсэхэд дүгнэлт өгнө.
- 2.9. Хүний нөөцийн газар нь Гүйцэтгэх захирлын хамтаар ББСБ-ын ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг гаргах бөгөөд албан тушаал дэвшин ажиллах боломжтой, чадварлаг ажилтнуудыг тодорхойлж, ур чадварыг нь хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
 - 2.10. ББСБ-ын эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааг бэлтгэхэд шаардлагатай сургалт хөгжлийн дотоод журам, төлөвлөгөөг Хүний нөөцийн газар нь Гүйцэтгэх захиралтай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд Нэр дэвшүүлэх хороо нь хэрэгжилтэд хяналт тавина.
 - 2.11. Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий байгууллагаас эрх бүхий албан тушаалтныг тохиромжтой бус этгээд гэж үзсэн мэдэгдэл ирүүлэх тохиолдолд мэдэгдэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, тохиромжтой этгээдийн шаардлага хангуулах ажлыг ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагын хамт хэрэгжүүлнэ.

3. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- 3.1. ББСБ-ын эрх бүхий албан тушаалтан нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан болон бусад урьдчилан харах боломжгүй, гэнэтийн шалтгааны улмаас албан тушаалаас чөлөөлөгдсөн тохиолдолд Нэр дэвшүүлэх хороо яаралтай хуралдаж, орлох этгээдийг сонгож, томилно.
- 3.2. Нэр дэвшүүлэх хороо болон Хүний нөөцийн газар хамтран эрх бүхий албан тушаалтны орон тоо гэнэтийн тохиолдлоор суларсан тохиолдолд тухайн албан тушаалд тохиромжтой, томилох боломжтой этгээдийг судалгааг хийж, нэр дэвшигчдийн судалгааг тогтмол шинэчилнэ.
- 3.3. Гүйцэтгэх захирал нь урт хугацаанд чөлөө авах, өвчтэй байх тохиолдолд түүнийг орлон ажиллах этгээдийг Нэр дэвшүүлэх хорооны санал болгосноор ТУЗ томилно.
- 3.4. Гүйцэтгэх захирлаас бусад удирдах албан тушаалтнууд буюу дэд захирал, газрын захирлууд урт хугацаанд чөлөө авах, өвчтэй байх тохиолдолд орлон ажиллах этгээдийг гүйцэтгэх захирал томилно. Ийнхүү томилсон этгээд нь тухайн ажил, үүргийг гүйцэтгэхэд мэдлэг, туршлагын хувьд хангалтгүй гэж Нэр дэвшүүлэх хороо үзсэн тохиолдолд Гүйцэтгэх захиралтай зөвшилцсөний үндсэн дээр томилгоог өөрчилж болно.

4. БУСАД

- 4.1. Энэхүү Бодлого болон холбогдох журмуудын хэрэгжилтэд Нэр дэвшүүлэх хороо хяналт тавьж ажиллах ба гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдэлнэ.

--ooOoo--

